НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025.05.30

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| **НЭГ. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| **Салбарын зорилго:** Хууль нэг мөр хэрэгждэг, хүний эрхийг дээдэлсэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх замаар тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулж, гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг ил тод болгоно. | | | | | | | |
| **Нэг. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| **1.1. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ** | | | | | | | |
| 1. | **Зорилт 1.1.1. Төрийн бүх шатны байгууллага шийдвэр гаргахад хүний эрхэд суурилсан хандлага, шударга байдлыг бий болгоно.** | | | | | | |
| 1.1 | Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас гарч байгаа шийдвэр, үйл ажиллагаанд жендэр, хүний эрхийн мэдрэмжтэй хандах, хүний эрхийн зөрчил гаргахгүй байна. | - | Хүний эрхийн зөрчил гаргалгүй ажилласан байна. | Хүний эрхийн зөрчил гараагүй ажилласан . | Нутгийн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаанд хүний эрх зөрчсөн шийдвэр гаргалгүй ажилласан байна. | Засаг даргын захирамж, Засаг даргын Тамгын газрын тушаал, төсвийн байгууллагуудын тушаалыг өдөр тутамдаа хянаж зөвлөн туслан ажиллаж байна. Эрх зүйн актуудыг гаргахдаа хүний эрхийн зөрчсөн эрх зүйн акт гаргалгүй ажиллаж байна. | 70% |
| 1.2 | Цахим технологи ашиглан Эрх зүйн сургалт, сурталчилгаа, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж, олон нийтийн эрх зүйн мэдлэгийг сайжруулна. | 500,0 | Олон нийтийн эрх зүйн мэдлэгийг сайжруулсан байна. | 2024 онд хийхээр төлөвлөсөн ажлыг 100 хувийн гүйцэтгэн ажилласан | 2025 онд эрх зүйн төлөвлөгөөг гарган биелэлтийг100 хувь ханган ажилласан байна. | Шинээр гарсан хууль тогтоомжийн цахим орчинд байршуулсныг шэйрлэн ажилласан. | 30% |
| 1.3 | Нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний шийдвэрийг гаргахаас өмнө цахим технологи ашиглан иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлж, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ. | - | Хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актуудыг гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлсэн байна. | 2024 онд хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гараагүй байна. | Нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний шийдвэрийг иргэд, иргэний нийгмийн байгууллагаар үнэлүүлж, олон | Нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт гараагүй тул хүлээгдэж байна. | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийтийн оролцоог ханган ажилласан байна. | | |
| 1.4 | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж, авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр боловсролын байгууллагатай хамтран олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 150,0 | Хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалтын тоо, бусад арга хэмжээ | Ахлах ангийн сурагчдын дунд "АВЛИГЫГ ТЭВЧЬЕ, СЭРГИЙЛЬЕ" сэдэвт reel уралдааныг зохион байгуулсан. 6 бичлэг ирсэнээс эхний 3 байрыг шалгаруулж шагнаж урамшуулсан нийт 150.0 мян төгрөг зарцуулсан. | Авлигыг үл тэвчих үзэл хандлагыг төлөвшүүлэх зорилгоор боловсролын байгууллагатай хамтран хүүхэд, залуучуудад авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах сургалт, сурталчилгаа зохион байгуулж тодорхой үр дүнд хүрсэн байна., | Хүлээгдэж байна. | - |
| 1.5. | Төрийн байгууллага, албан хаагч, иргэд, олон нийтэд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа явуулж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | - | -Иргэд, олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан байдал<br>-Авлига, ашиг сонирхлын зөрчлийн тоо | "Хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдүүлэг гаргах" сэдвээр байгууллагын дарга, багийн дарга, нягтлан бодогч, татварын улсын байцаагч нарт сургалт | Соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн орон нутагт хамаарах заалтын хүрээнд боловсруулсан аймгийн 2025 оны төлөвлөгөөг Төрийн байгууллага бүр хэрэгжүүлэн ажиллаж байна. Авлигын эсрэг сургалтыг албан хаагчидад 1 удаа зохион байгуулсан . | 70%. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохион байгуулсан. Сургалтад нийт 9 албан хаагч хамрагдсан. | | | |
| 2 | **Зорилт 1.1. 2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд олон нийтийн оролцоонд тулгуурласан бодлого хэрэгжүүлж, гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан нөхцөлийг судлан тогтоох арга зүйг шинэчилж, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн тоог үе шаттай бууруулна.** | | | | | | |
| 2.1. | Сумын төв болон Баянтээг 2 дугаар багийн төвийг "Ногоон бүс" болгох зорилгоор замын хяналтын пост, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайг Монгол улсын камерын хяналтын стандарт MNS:6324-д нийцсэн теле хяналтын камертай болгох. | 101.420,0 | Монгол улсын камерын хяналтын стандарт MNS:6324-д нийцсэн теле хяналтын камертай болсон байна. | Сумын нийтийн эзэмшлийн талбайд чиглэлийн камер 4, эргэдэг камер 5 хэвийн ажилллага атай | Иргэдийн амьдрах орчны аюулгүй байдал сайжирна. | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын төв болон Баянтээг 2 дугаар багийн төвийн камержуулах ажлыг сумын Засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулан ажилласан. Тендерийн үнийн саналд Өвөрхангай цахим сүлжээ ХХК, Сандо Тэнга инженеринг ХХК, Девсофт ХХК-иудын үнийн санал ирүүлснийг үнэлгээний хорооны хуралдан хамгийн бага үнийн санал ирүүлсэн Девсофт ХХКомпани нь 99,657,863 төгрөгийн үнийн саналаар хамгийн сайн тендерээр шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. | 100% |
| 3. | **Зорилт 1.1.3. Хууль сахиулах болон зарим хяналтын байгууллагууд, тэдгээрийн алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.** | | | | | | |
| 3.1 | Архивын лавлагаа мэдээллийн цахимжуулалтыг эрчимжүүлж, үйлчилгээг хялбарчилна | 1200,0 | Хүчин чадал үзүүлэлт сайтай техник тоног төхөөрмжөөр хангах | Техник тоног төхөөрмжийн үзүүлэт хүчин чадал муу | Архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээг хялбарчилж сайруулна. | Архивын лавлагаа мэдээлэл олгох тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах зорилгоор хурдан скайнер худалдан авч. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2012-2015 оны 8 боть буюу 1000 хуудас Малын А дансыг цахим хэлбэрт шилжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3. | Төрийн байгууллагуудад дотоод хяналтын нэгж ажиллуулан, төрийн албан хаагчдын шударга байдлыг нэмэгдүүлнэ. | - | Дотоод хяналтын нэгж ажилладаг байгууллагын тоог бууруулахгүй байх.<br>-2-оос доошгүй удаагийн арга зүйн зөвлөмжийг өгч ажилласан байх | Төрийн байгууллагуудын 89% нь буюу 8 байгууллага дотоод хяналтын нэгжтэй. | Нийт байгууллагын 90 хувийг дотоод хяналтын нэгжтэй болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулсан байна. | Сумын төсвийн байгууллагад дотоод хяналтын нэгжээ байгуулан байгууллагынхаа даргын тушаалаар баталгаажуулан ажиллаж байна. | **70%** |
| | **1.2. ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТ** | | | | | | |
| 4. | **Зорилт 1.2.1 Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлэн, дайчилгааны төлөвлөлтийг шинэчилж, хүүхэд залуучуудын цэрэг-эх оронч үзлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 4.1 | Дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжид тотодгол хийж бэлэн байдлыг хангана | 500,0 | Томилгоот нэгжийн бүрэлдэхүүний хувиар | сумын томилгоот бүрэлдэхүүний 10-15 хувийг хамруулна. | орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжид тотодгол хийж бэлэн байдлыг хангасан байна. | | |
| 4.2 | Хүүхэд залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалт, арга хэмжээг тогтмолжуулна. | 1000,0 | Зохион байгуулагдсан арга хэмжээнд 100% оролцсон байна. | - | Иргэдийн эх орноо хамгаалах бэлтгэлжилтийг дээшлүүлэх замаар Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх бодлогыг орон нутагт түгээн дэлгэрүүлнэ. | Өвөрхангай аймгийн Насан туршийн суралцахуйн нэгжийн нийгмийн ажилтан Б.Сүрэн мэргэжилтэн Б.Эрдэнэдулам, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын мэргэжилтэн Т.Төвхөнбаяр нар Эрчүүдэд тулгамдаж буй асуудал, Харилцаа чухал уу, Хандлага чухал уу, Гэр бүлийн тухай ойлголт зэрэг сэдвээр цэргийн насны 84 залуучуудад сургалт зохион байгуулсан. Насан туршийн | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | суралцахуйн төвийн багштай хамтран "Дэлхийн мөнгөний 7 хоног-2025" хоног аяны хүрээнд ЕБС-ийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд "Санхүүгийн боловсрол олгох" чиглэлээр сургалт, нөлөөллийн зохион байгуулж давхардсан тоогоор 170 хүүхэд, "Мэргэжил сонголт" сэдвээр 9,10 дугаар ангийн сурагчдад сургалт зохион байгуулж 56 хүүхэд, Цэргийн албаны тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Эх оронч үзэл сэдвээр 10,11 дүгээр ангийн сурагчдад сургалт зохион байгуулж 69 хүүхэд тус тус оролцож мэдлэг, боловсролоо дээшлүүлсэн. | |
| 4.3 | Сумын онцгой комисс мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэлжилтийг сайжруулна. | 200.0 | Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэмцэх бэлтгэлжилтэд сумын онцгой комисс мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг 80%-иас дээш хамруулна. | Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг амжилттай зохион байгуулж 94.1% -тай үнэлэгдсэн. | сумын мэргэжлийн анги болон гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг олгосон байна. | Сумын гамшгаас хамгаалах, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг аймгийн ОБГ-аас зохион байгуулсан сургалтанд 04-р сард хамруулсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.4 | Иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн арга хэмжээний хүртээмжийг дээшлүүлнэ. | 300,0 | гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн арга хэмжээг бүхий л хэлбэрээр зохион байгуулна. | Иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан | иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг олгосон байна. | Сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгон боловсруулж 1-р улиралд аймгийн Онцгой байдлын газарт хянуулж сумын Засаг даргаар батлуулсан. Монгол улсын засгийн газрын 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх" журам, 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үеийн дайчилгаа, нүүлгэн шилжүүлэх" журмыг хэрэгжүүлэн 2025 оны 03 сарын 28-ны өдрийн 16 цагт "Зарлан мэдээллийн дохио"-гоор иргэд олон нийт цугларах цэгт Онцгой комисс болон мэргэжлийн ангийн нийт гишүүд, иргэд, багаж хэрэгсэл машин техник хэрэгсэлтэй оролцсон байна. Энэ арга хэмжээний үеэр ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн дарга Онцгой байдлын ерөнхий байдлын А/379 дүгээр тушаалаар батлагдсан "Мэргэжлийн ангийн дүрмийн талаар танилцуулж, "Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт"-ыг аж ахуй нэгж байгууллага, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн болон ард иргэдэд зохион байгуулсан | 90% |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Салбарын зорилго: Төсөв санхүүгийн үйл ажиллагааг технологийн дэвшлийг ашиглан үр ашигтай удирдан, үр өгөөжийг нэмэгдүүлж, төрийн бүх шатанд төсвийн сахилга хариуцлагыг сайжруулна.** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.Санхүү, төсөв** | | | | | | | |
| 5. | **Зорилт 2.1.1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж төсөв үр ашигтай, хэмнэлтэй байхаар төлөвлөгдөн төрийн бүх шатны төсвийн сахилга хариуцлагыг сайжируулна.** | | | | | | |
| 5.1. | Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг үр дүнд суурилан төлөвлөж, гүйцэтгэлийг хангана. | 2,243,000,0 | Төсвийг үр дүнд суурилан төлөвлөж, өр авалга үүсгэхгүй ажиллана. | 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харъяа байгууллагуудад зарцуулагдах төсвийн хэмжээг нийт 1,981,548.8 мян.төгрөгөөр үр дүнд суурилан төлөвлөж гүйцэтгэлийг хангаж ажилласан | төсвийг төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжирсан байна. | 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харъяа байгууллагуудад зарцуулагдах төсвийн хэмжээг нийт 2,243,194.0 мян.төгрөгөөр үр дүнд суурилан төлөвлөж гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна. 2025 оны 05 дугаар сарын 31 ны байдлаар нийт 1,007,344.4 мян.төгрөгийн санхүүжилтыг төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харъяа байгууллагуудад төсвийн хуваарийн дагуу олгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2. | Төсвийн ил тод байдлыг хангах замаар шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллана. | - | - төсвийн 9 байгууллага, Баянтээг ХК, зэрэг нийт 13 байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулалтад тогтмол хяналт тавина. | 2024 онд Шилэн дансаны /www.shilendans.gov.mn/-д төсвийн 8 байгууллага, 125 мэдээлэлийг, Баянтээг ХК 116 мэдээлэлийг, Төрийн ссан 108 мэдээллийг тус тус хуулийн хугацаанд байршуулсан. | Төрийн 8 байгууллага, Төрийн сан. Баянтээг ХК зэрэг нийт 13 байгууллагын Хагас бүтэн жилийн тайлан, 1-12 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, өр авлагын мэдээ, орон нутгийн орлогын мэдээ зэргийг сумын цахим хуудас болон шилэн дансны мэдээллийг 100% тавьсан байна. | 8 Төсвийн байгууллага 4 сан 1 ХК –ны төсвийн гүйцэтгэлийн мэдээ,өр авлагын, орон нутгийн орлого, санхүүжилтийн 1-5 сарын мэдээг шилэн дансанд байршуулсан. Төсвийн ил тод байдлыг хангах Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 3 бүлэгт хамаарах мэдээллийг хуульд заасан хугацаанд чанартай үнэн зөв тавьж хэвшээд байна.<br><br>2025 оны эхний улирлын шилэн дансны үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар хяналт шалгалт хийсэн. Тухайн хяналт шалгалтаар Нарийнтээл сумын цэцэрлэг, Баянтээг багийн сургууль тус бүр нэг мэдээлэл байршуулаагүйг нөхөж байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3. | Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөрийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулна. | 200,0 | - Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй иргэдийн тоо<br>- хууль хяналтын байгууллагад шилжүүлж, барагдуулсан иргэдийн тоо | Хугацааа хэтэрсэн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн зээлийн үлдэгдэл 64% буурсан. | Сум хөгжүүлэх сангаас зээл аваад хугацаа нь дууссан боловч төлөгдөөгүй, явцын хэтрэлттэй зээлүүдийг иргэд, аж ахуйн нэгжээр бүрэн төлүүлэх, тус сангийн хөрөнгийн ашигт байдлыг сайжруулах, эргэлтэд оруулах, | Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл оны эхэнд 157,878.3 мян.төг байсан. 06 сарын 01 ний байдлаар хугцаа хэтэрсэн зээл 10,067.4 мян.төг, хэвийн зээл 8,466.4 мян.төг буюу нийт зээлийн үлдэгдэл 11.7 хувиар буурсан. 06 сарын 01 ний байдлаар шүүхийн байгууллагад шилжсэн 4 иргэний 10,242.3 мяг.төг байна. Шүүхийн байгууллагад шилжсэн иргэн 1 иргэнд холбогдох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллааг түдгэлзүүлэх тухай тогтоолын дагуу хэсэгчлэн түдгэлзүүлсэн, 1 иргэнд холбогдох шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллааг дуусгавар болгох тухай тогтоолын дагуу дуусгавар болгосон. Тухайн хоёр зээлдэгчийн зээлийг шүүхийн тогтоолын дагуу сангаас хаах хүсэлтийг холбогдох материалын хамт Сангийн яамд хүргүүлсэн. 2025 онд шинээр шүүхийн байгууллагад шилжүүлсэн зээл байхгүй. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.4 | Төсвийн тухай хуулийн хүрээнд сумын Хоршоо хөгжүүлэх сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулах чиглэлийг баримтлан, журмын дагуу зарцуулж ажиллана. | - | - Сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулсан эсэх.<br>- Тодорхой үр дүнд хүрсэн эсэх. | Орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулж ажилласан | Сумын орон нутгийн хөгжлийн сан болон бусад сангуудын хөрөнгийг тодорхой, үр дүнтэй төсөл арга хэмжээнд зарцуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна. | 2025 онд Хоршоо хөгжүүлэх сангаас программын эрхийн төлбөр, зээлийн төлөлт, хяналт, сургалтын хүрээнд зарцуулалт гараагүй ба зээл олголт хийгдээгүй сангийн үлдэгдэл үлдэгдэл 93,661.5 мян.төг байна. Эрсдэлээс хамгаалах сангаас мал хамгаалал, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, бусад сантай холбоотой зардлын хүрээнд зарцуулалт гараагүй жилийн эцсийн үлдэгдэл үлдэгдэл 24,565.8 мян.төг байна. Журам зөрчсөн үр ашиггүй зарцуулалт хийгдээгүй. | 100% |
| 5.5 | Төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэн төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан төсвийн шууд захирагч, төрийн албан хаагчтай хариуцлага тооцох, ил тод шуурхай механизмыг бий болгон хэрэгжүүлнэ. | - | - Монгол Улсын 2023 оны төсөвтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын шийдвэрийг тухай бүр мөрдөж ажилласан эсэх<br>- Төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх.<br>- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд | 1-12 сарын мэдээ, мэдээллийг цахим хуудас /www.shilendans.gov.mn/-т тухай бүр мэдээлж, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлж, өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар | 1. Төрийн хэмнэлтийн тухай" хуулийг мөрдөн ажиллана.<br>2 Төсвийг хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулж , өр төлбөр үүсгээгүй, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй ажилласан байна.. | Төрийн хэмнэлтийн тухай" хуулийг мөрдөн ажиллаж байна. Төсвийг анхан шатны баримтад тулгуурлан, батлагдсан төсөвт багтаан гүйлгээг хийж байна. Төсвийг зориулалт бусаар зарцуулаагүй хөтөлбөр зориулалтын дагуу зарцуулж байна. Төсвийн орлого, төсвийн гүйцэтгэлийн мэдээг Шилэн данс болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулан төсвийг ил тод нээлттэй болгож байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийг бүрэн, үнэн зөв, хугацаанд нь оруулах. | зарцуулааг үй, аймаг, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлж ажилласан | | | |
| 6 | **Зорилт 2.1.2. Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын бүртгэлээр тавих хяналт, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 6.1. | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх, эзэнжүүлэх, үр ашгийг тооцон, бүртгэлээр хяналт тавих. | - | 2025 онд Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээгээр | 2024 онд Баянтээг ЕБС 5,337.0 мян.төг, ИТХ 18,500.0 мян/төг, ЗДТГ 10,605.0 мян.төг, Соёлын төв 20,866.0 мян.төг, ЭМТөв 16,816.7 мян.төг, СӨББ 1,489.0 мян.төг, ЕБС 6,632.7 мян.төг нийт 80.246,4 мян.төг- | Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх, эзэнжүүлэх, үр ашгийг тооцон, бүртгэлээр хяналт тавьж ажилласан байна. | 2025 онд ЗДТГ 227,232.4 мян.төг, Соёлын төв 114,321.89 мян.төг, СӨББ 19,800.0, Баянтээг СӨББ 19,980.0 мян.төг, ЕБС 94,057.1 мян.төг нийт 475.391.4 мян.төг-ийн хөрөнгө орлогот авч бүртгэлд тусгасан Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх, эзэнжүүлэх болон үр ашгийг тооцон, бүртгэлээр хяналт тавьж ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ийн хөрөнгө орлогот авч бүртгэлд тусгасан. | | | |
| 6.2. | Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, тэдгээрийн бүртгэл мэдээлэл, үнэлгээ, тайланг ил тод нээлттэй болгон, өмч эзэмшигчдийн хариуцлагыг дээшлүүлнэ. | - | - 2025 онд шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтын хэмжээгээр<br>- Балансад байгаа хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, тайланг ил тод байлгах. | Балансад бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг гэрчилгээжүүлэн, газар эзэмших, ашиглах эрхийг үнэлж, бүртгэх, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлж санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан. | Төсөв ил тод нээлттэй, төсөв үр ашиггүй зарцуулагдахгүй алдагдлыг багасгаж, төсвийн сахилга хариуцлага сайжирсан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан байгууллага бүрд "өмч хамгаалах байнгын зөвлөл" дотоод хяналтын баг төлөвлөгөөний дагуу өмч хөрөнгөд хяналт тавин бүрэн бүтэн байдлыг хангаж, холбогдох албан хаагчидтай хамтран ажиллаж байна. Төсвийн байгууллагууд 2025 оны 04 сарын 25 ны өдрийн дотор umch.sgov.mn өмч хөрөнгийн програмд өөрийн байгууллагад бүртгэлтэй бүх хөрөнгийн зураг, мэдээлэл, тайланг 100% оруулж ажилласан | 100% |
| **7.** | **Зорилт 2.1.3. Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар хүний оролцоог бууруулж, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 7.1. | Төрийн худалдан авах ажиллагаанд технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, хэрэгжүүлэн ажиллана. | - | Худалдан авах үйл ажиллагааны тендер шалгаруулалтыг 100% цахимаар явуулна. | 2024 онд нийт 18 худалдан авах ажиллагаа зохион байгуулсны 13 буюу 72% нь цахимаар, | Худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулахдаа иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, тендер шалгаруулалтыг 100 цахимаар явуулсан байна. | 2025 онд Орон нутгийн хөгжлийн сан, мал аж ахуйн албан татвараар нийт 1,211,415.6 мян.төгрөгийн санхүүжилтээр шууд худалдан авалтын аргаар хийгдэх 236,995.6 мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 ажил, харьцуулалтын аргаар хийгдэх нийт 974,420.0 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 5 буюу 28% нь босго үнэ даваагүй учир уламжлалт аргаа зохион бөайгуулагдсан. | | мян.төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 ажилыг ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулан 2025 онд нийт уг ажлын төлөвлөгөөг 01 сарын 10-ны дотор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "tender.gov.mn" сайтад шивж баталгаажуулан төлөвлөгөөний дагуу зарцуулж байна. | |
| 7.2. | Бүх шатны худалдан авах ажиллагаанд болон түүний гүйцэтгэлийн явцад хяналт, шалгалтыг тогтмол явуулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангана. | - | Гэрээт ажлын гүйцэтгэл чанар сайжирсан байна. | сумын Засаг даргын захирамжаар иргэний төлөөлөл орцуулсан 5 хүний бүрэлдхүүнтэй хяналтын ажлын хэсэг ажилласан. Мөн ИТХ-ийн хяналтын ажлын хэсэг ажилд хяналт тавин ажилласан | Худалдлан авах ажилллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, тухайн ажлыг хийж байгаа хугацаанд нь ИТХ, ЗДТГ-аас хууль журмын дагуу хяналтын ажлын хэсэг байгуулан тогтмол хяналт тавин ажилласан байна. | 2025-онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 27 төсөл арга хэмжээ хийхээр төлөвлөгдсөн. Худалдан авах үйл ажиллагааны хуулийн дагуу тендер шалгаруулалтыг 100% цахимаар явуулсан. Шууд худалдан авах ажиллагааны аргаар 8 ажил, харьцуулалтын аргаар 4 ажил тус тус зарлагдан гүйцэтгэгч шалгарсан. Ажлын гүйцэтгэлийн явц болон ажил хүлээлцэх хяналт, шалгалтыг явуулж, Засаг даргын захирамжаар батлагдсан 6 ажлын хэсэгт 5 иргэд, олон нийтийн төлөөлөл оролцуулан хяналт тавьж ажиллаж байна. | 100% |
| 8. | **Зорилт 2.1.4. Татварын бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, татварын үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад жигд хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.1 | Иргэн, аж ахуйн нэгжийн татварын боловсрол, татвар төлөх сэтгэлгээ хандлагыг сайжруулах замаар татварын бааз суурийг нэмэгдүүлнэ. | 922.0 | Иргэн, аж ахуйн нэгжийн татварын боловсрол, татвар төлөх сэтгэлгээ хандлага сайжран татварын бааз суурь нэмэгдэнэ. | "Шинээр байгуулагд аж байгаа болон орон нутагт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд урамшууллын "И-баримт" системийг нэвтрүүлэх эд дэмжлэг үзүүлэн системийн ашиглалтын талаар сургалт, сурталчилгааг хийж ажилласан | Иргэн, аж ахуйн нэгжийн татварын боловсрол, татвар төлөх сэтгэлгээ хандлага сайжран татварын бааз суурь нэмэгдэнэ. | 2025 онд шинээр бүртгэгдсэн татвар төлөгчдэд татварын хууль тогтоомж болон татварын хуулийг хэрэгжүүлээгүйгээс гарах эрсдэл, төлбөрийн баримт олгох, төлбөрийн баримт хэвлэж өгөөгүйн улмаас гарах эрсдэлийн талаар талаар сургалт, мэдээллийг зохион байгуулсан. Шинээр бүртгэгдсэн аж ахуйн нэгж төлбөрийн баримт хэвлэх тоног төхөөрөмж шинээр суурилуулж иргэдэд худалдан авалт тутамд төлбөрийн баримтыг тогтмол өгч хэвшсэн. | 70% |
| 8.2 | Сумын орон нутгийн төсөвт төвлөрөх татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх арга хэмжээ авч ажиллана. | - | Татварын орлогын төлөвлөгөөг сар бүр нэр төрөл бүрээр жигд хангаж биелүүлэх | 2024 оны жилийн байдлаар татварын орлогын төлөвлөгөө 792,359.4 мян.төг гүйцэтгэл 766,916.4 мян.төг биелэлтийн хувь 96.7, Татварынт бус | Сумын орон нутгийн төсөв төвлөрөх татварын төлөвлөгөөг сар бүр нэр төрөл бүрээр жигд хангаж 100% биелүүлж татварын өр авлага үүсгэхгүй байх. | 2025 оны төсвийн татварын болон татварын орлогын төлөвлөгөөг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу суманд төвлөрүүлэх орлогыг нэр, төрөл бүрээр төлөвлөсөн. 2025 оны 05 дугаар сарын 31 ны өдрийн байдлаар татварын орлогын төлөвлөгөө 318,779.6 мян.төг гүйцэтгэл 439,538.5 мян.төг биелэлтийн хувь 100 байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | орлогын төлөвлөгөө 90,435.8 мян.төг гүйцэтгэл 101,950.6 мян.төг биелэлтийн хувь 100, Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө 340,321.6 мян.төг гүйцэтгэл 132,546.07 мян.төг биелэлт 38.9 хувь байна." | | | |
| **2.2. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ** | | | | | | | |
| Салбарын зорилго: Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тооноос чанарт шилжүүлж, бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулан мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж, газар тариалангийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 9. | **Зорилт 2.2.1. Мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулна.** | | | | | | |
| 9.1. | Нарийнтээл сумын Тээлийн улаан ямааг омог болгон баталгаажуулж, ангилалт хийх цөм сүрэг бүрдүүлэх, өсвөр хээлтүүлэгч бэлтгэнэ. | ОНХСан 20000,0 | Тээлийн улаан ямааг омог болгон баталгаажуулж, ангилалт хийн цөм сүрэг бүрдүүлж, өсвөр хээлтүүлэгч бэлтгэнэ | Тээлийн улаан ямааны судалгаа шинжилгээний ажлыг нэгтгэн Тээлийн улаан ямааны омгийн тодорхойл | ХАА яамны ажлын хэсгээр хянуулж "Улаан ямаа" Омог болгох асуудлыг дуусгах. | Нарийнтээл суманд үржүүлж буй "Тээлийн улаан" нутгийн шилмэл ямааг "ОМОГ"-оор баталгаажуулах ажлын хэсэг Нарийнтээл суманд ажиллалаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан "Үржлийн малд хянан магадалгаа хийх, баталгаажуулах журам"-ын | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | олтыг бичиж МААЭШХүрээлэнгийн их эрдэмтэдийн хурлаар оруулж 100 хувийн саналаар дэмжигдэн ХХААЯ нд ямааны омгийн тодорхойлолтыг 2024 онд цөм сүргийн 2000 ямааг ангилж ялган тэмдэглэн бүртгэл хөтөлж livestock.mofa.gov.mn бүртгэлийн сестэмд бүртгэсэн. | | дагуу ХХААХҮЯ-наас томилогдсон ажлын хэсэг 2025 оны 5-р сарын 8–16 мс -ны өдрүүдэд Нарийнтээл суманд ажиллалаа. Ажлын хэсэг "Тээлийн улаан" нутгийн шилмэл хэвшлийн ямаанд явуулсан үржил селекцийн ажилд хяналт шалгалт хийж, ямааны биеийн үндсэн хэмжээг авч хэмжилтүүдийг хийв. Ангилалт хийж явахдаа малчин өрхийн 24 хээлтэгчээс мөн ухны сууриар орж 7 ухнаас цусны дээж авав. 44 ямаанаас ноолуурын дээж авч голч тодорхойлохоор дээжийг Нэхмэлийн хүрээлэнд хүргүүлэв. Мөн 44 ямааг газар дээр самнан ямааны дундаж гарцыг тодорхойлов. Мөн үржлийн сүргийн малчдын ямааг үзэж биеийн үндсэн хэмжилт хийв. Ажлын хэсгийн дүгнэлтээр Нарийнтээл сумын "Тээлийн улаан" ямааг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хурлаар "ОМОГ"-оор баталгаажуулахаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.<br>Энэ нь нутгийн шилмэл ямааг албан ёсоор бүртгүүлж, цаашдын үржил селекц, ноолуурын үйлдвэрлэлд чухал алхам болох юм. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цөм сүргийн 500 ямаанд ангилалт хийж ээмэг дугаар нь хаягдсан болон шинээр нийт 279 ямааг ээмэглэж бүртгэлжүүлэв. | |
| 9.2 | Малын тоо толгойн албан татвараас малын чанарыг сайжруулж, мал зүйчийг багаж тоног төхөөрөмжөөр хангана. | ОНХС 2,500.0 | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | - | Бүрдсэн орлогын 70-аас багагүй хувийг малын чанар сайжруулах, , мал зүйчийн багаж тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээнд зарцуулсан байна. | 57,3 сая төгрөг төвлөрсөн байна. 24 сая төгрөг малын үржил, малын эрүүл мэндийн зардалд гарсан байна. | 70% |
| 9.3 | Залуу малчдыг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 500,0 | Залуу малчдыг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангана. | - | Залуу малчдыг дэмжих хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Хүлээгдэж байгаа | |
| 9,4 | Үхэр сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлж, малыг эдийн засгийн эргэлтэд оруулан тоо толгойгоос чанарт шилжүүлнэ. | | Үхэр сүргийн нийт малд эзлэх хувийн жин нэмэгдэж үхэр сүргийн чанар сайжирсан байна. | Нийт мал сүргийн 5,9 хувьд хүрсэн байна. | Нийт мал сүргийн 6,0 хувьд хүрсэн байна. | Үхэр 10210, хонь 64597 болж нийт мал сүргийн 41,1 хувийг эзэлж байна. | 100% |
| 9.5 | Цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэн, мал сүргийг даатгалд хамруулах ажлыг зохион байгуулна. | 1500,0 | ААНэгж байгуулж, цөм сүргийн болон ээмэг дугаар нь хаягдсан хээлтүүлэгч малыг бүрэн ээмэгжүүлсэн байна. | 2024 онд цөм сүргийн 2000 ямааг ангилж ялган тэмдэглэн бүртгэл хөтөлж livestock.mofa.gov.mn бүртгэлийн | Цөм сүргийн болон хээлтүүлэгч малын ээмэг дугаар нь хаягдсан малын тоогоор ээмэг худалдаж авах | Цөм сүргийн 500 ямаанд ангилалт хийж ээмэг дугаар нь хаягдсан болон шинээр нийт 279 ямааг ээмэглэж бүртгэлжүүлэв. Хаан банк, Төрийн банк зэрэг байгууллага аж ахуй нэгж МИД-д 45 малчин өрхийн 11000 малыг буюу нийт малчин өрхийн 7,4 хувийг 6,1 сая төгрөгөөр даатгалд хамруулсан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сестэмд бүртгэсэн. | | | |
| 10 | **Зорилт 2.2.2. Бэлчээр ашиглалт, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 10.1 | Атаршсан талбайг баг бүрт хашаалж малын тэжээл тариалалтыг сайжруулан, малчдын түвшинд өвс, тэжээлийн нөөцийг нэмэгдүүлнэ. | 50000,0 ОНХС | - Атаршсан талбайг хашаажуулж эргэлтэнд оруулсан хэмжээ - Малын тэжээл тариалсан талбайн хэмжээ | Нийт 13 га талбайг хашаажуулж малын тэжээл тариалсан. | 16 га-г хашаажуулж малын тэжээл тариална. | Малын хөлийн албан татвараар Өндөр хөмөг 3 дугаар баг, Цагаан-Овоо 4 дүгээр багуудад тус бүрд нь 5 га нийт 10 га атарсан газрыг хашаажуулж малын тэжээл тарихаар төлөвлөгдөж тендер зарлагдаж байна. | 70% |
| 10.2 | Сумын аюулгүйн нөөцийг малын тоо толгойн албан татвараар бүрдүүлнэ. | 20000.0 | Хадлан тэжээлийн бэлтгэл ажлыг суурь түвшингээс бууруулахгүй байна. | 2024 онд 46,8 тн буюу 2600 боодол өвс сумын аюулгүйн нөөцөд бүрдүүлсэн. | Сумын аюулгүйн нөөцөд бүрдүүлэх өвс тэжээлийг урд оны түвшингээс бууруулахгүй байх | Засаг даргын нөөцөөс 15.000.000 /Арван таван сая/ төгрөгт 1000 боодол өвс, малын тоо толгойн албан татвараар 19.965.000 /Арван есөн сая төгрөг/ 2000 боодол өвс, 200 хивэг шуудай хивэг нөөцөлж хавар цаг агаарын хүндрэлтэй үед малчдад тусалсан. | 70% |
| 11 | **Зорилт 2.2.3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд тулгуурласан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг хөгжүүлэн малчдын хоршоог чадавхжуулна.** | | | | | | |
| 11.1 | ."Шинэ хоршоо-хөдөлгөөн"-ийг сумын хэмжээнд үргэлжлүүлэн өрнүүлж, малчдын хоршоодыг хөнгөлөлттэй зээлд хамрагдахад дэмжлэг болж ажиллана. | 500,0 | ."Шинэ хоршоо-хөдөлгөөн"-ий хүрээнд малчдын хоршоодыг хөнгөлөлттэй зээлд хамрагдахад хамтарч ажиллана | - | малчдын хоршоодыг хөнгөлөлттэй зээлд хамруулж үйл ажиллагааг нь дэмжин өргөжүүлсэн байна. | "Ар мандалын булаг хоршоо " нь 2024 онд Шинэ хоршоо хөдөлгөөнөөс 34 сая төгрөгийн зээл авч "Сүүний чиглэл"- ийн үнээ худалдан авч үйл ажиллагаагаа эрхэлж байна. Хоршоо байгуулах сонирхолтой 1 иргэнд зөвөлгөө өгч ажилласан. | 100% |
| 11.2 | Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг чадавхжуулж мэргэшүүлэх урт богино хугацааны сургалтад хамруулана. | 200,0 | Мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хоршоодыг | Цахим сургалт - 1<br>Танхим сургалт - 2 | Орон нутагт ажлын байр бий болж иргэдийн амьдралын чанар сайжирч өрхийн орлого нэмэгдсэн байна. | 2023 онд "Мах сүүний чиглэл"-ээр 2 өрхөд 21 сая төгрөгийн зээл олгосон. Үүнээс: Т.Мөнхбаатар нь 8 үнээ худалдан авч төслийн дагуу үйл ажиллагаагаа эрхэлж байна. 2025 оны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | чадавхжуулсан байна. | Туршлага судлах сургалт - 1 | | байдлаар 13 үнээтэй болж тоо толгойг 5-аар нэмэгдүүлсэн. Харин Т.Ганболд нь 4 охин бяруу 5 тугалтай үнээ худалдан авсан. 2025 оны байдлаар 4 тугал 4 үнээтэй болж малын тоо буурсан. | |
| 12. | **Зорилт 2.2.4. Мал эмнэлгийн ононшилгоо, шинжилгээний багаж төхөөрөмжийг нэмэгдүүлж, мал, амьтны гоц халдварт, халдварт, өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдваргүй өвчний өвчлөлийг бууруулна.** | | | | | | |
| 12.1 | Орон нутгийн төсвийн зардлаар хийгддэг дотрын халдарт хордлого, цусан халдварт, дуут хавдар, энтеробактериоз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг сумын хэмжээнд зохион байгуулна. | 23.000,0 | угаалга, тарилга, туулгалтад 90-ээс дээш хувийн гүйцэтгэлтэй хийсэн байх | Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ДХХ-ын вакцинд 16598 мал, шөвөг ярын вакцинд 15775 ишиг, Цусан халдварты н вакцинд 1387 үхэр, ДХХ-Энтеробак териоз вакцинд 12326 хонь, Галзуугийн вакцинд 7931 бод, бог, Боомын | Мал сүргийг угаалга, тарилга, туулгалтад 100% хамруулна. | 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/32 тоот Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай захирамжийн дагуу дараах вакцинжуулалт хийгдэнэ. Үүнд: Бумбат суварга, Бумбат-Ур мал эмнэлэгүүд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд ДХХ-ын вакцинд 15800 мал, шөвөг ярын вакцинд 12000 ишиг, Цусан халдвартын вакцинд 1080 үхэр, ДХХ-Энтеробактериоз вакцинд 12000 хонь, Галзуугийн вакцинд 7200 бод, бог, Боомын вакцинд 13000 бод, бог, сахуугийн вакцин 100 унага нийт 61180 толгой малын мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж өгсөнд хяналт тавьж ажиллав. Мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэлийг шалгахад Бумбат суварга мал эмнэлгийн үйлчилгээний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | вакцинд 13272 бод, бог, Дуут хавдартын вакцинд 399 үхэр, сахуугийн вакцин 100 унага нийт 67788 мал хамрагдаж гүйцэтгэл нь 98 хувь | | нэгж шөвөр яр 5940 ишиг, ДХХ 8712 хонь нийт 14652 мал хамрагдаж гүйцэтгэл нь 99 хувьтай хийгдэж байна. Бумбат-Ур мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь шөвөг яр 5940 ишиг, ДХХ 6930 хонь нийт 12870 мал хамрагдаж гүйцэтгэл нь 99 хувьтай хийгдэж байна. 06 дугаар сардаа дотрын халдварт хордлого, ДХХ-Энтеробактериоз, Шөвөг яр өвчний дархлаажуулалтын тайлангаа мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээсээ татан авахаар төлөвлөж байна.<br>Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлуулан аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэн ажилласан. Үүнд: угаалга 123000 мал, туулга 141910 мал, боловсруулалт 38450 нийт 303360 мал мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж өгсөнд хяналт тавьж ажилласан. Мал эмнэлгийн нэгдсэн системд гүйцэтгэл нь туулга 55100 буюу 40 хувь, боловсруулалт 10335 буюу 30 хувьтай хийгдэж байна. | |
| 12.2 | Сумын хэмжээнд үхэр сүргийг бруцеллёзын халдваргүй болохыг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний | 6000,0 | - үхэр сүргийг бруцеллёзын халдваргүй | Дэлхийн банкны санхүүжилттэй хэрэгжиж | Бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх шинжилгээнд монголын үхэртэй 20 өрхөөс 3 удаа | 2025 оны 07 дугаар сараас хойш хийгдэхээр төлөвлөгдөж байгаа | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгжүүд сумын түвшинд лабораторийн анхан шатны шинжилгээ хийж, хүнсний аюулгүй байдлыг хангана. | | болохыг баталгаажуулна.<br>- мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд сумын түвшинд лабораторийн анхан шатны шинжилгээ хийнэ. | байгаа МАА-ЭЗЭН төслийн хүрээнд "Эрүүл сүрэгтэн" гэрчилгээ олгох туршилтын хөтөлбөрийн дагуу 29 өрхийн 78 дээжинд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх сүүний шинжилгээг МЭХЦХЦэгийн лабораторит шинжлэхэд зэрэг дээж гараагүй. | шинжилгээнд төлөвлөгөөний дагуу хамруулсан байна. | | |
